



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/238

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.1, 10.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хан Хэнтийн аварга дэвжээ" төрийн бус байгууллагаас гаргасан санал хүсэлтийн дагуу аймаг байгуулагдсаны 94 жилийн ойн баяр наадамд барилдах Хэнтий аймгийн бөхчүүдийн бэлтгэл сургуулилтын зардалд зориулж 1000000 /нэг сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА